

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар /С.Сүнчин/-т, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Салбарын хяналтын газар /С.Ганзориг/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн программ хангамжийг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх тухай” А/193 дугаар тушаалыг тус хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж /цаашид “программ хангамж” гэх/-д үнэлгээ хийж, шаардлагад нийцсэн программ хангамжийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан тушаалаар байгуулагдсан байнгын ажиллагаатай ажлын хэсэг программ хангамжид үнэлгээ хийж, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Ажлын хэсэг дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

2.1.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-2;

2.1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-2;

2.1.3. Тагнуулын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл -1;

2.1.4. Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, нийгэмлэгийн төлөөлөл-2;

2.3. Ажлын хэсгийн үйл ажиллагаа хуралдаан хэлбэртэй байна. Ажлын хэсгийг төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс сонгож ахална.

2.4. Ажлын хэсэг үйл ажиллагаандаа “Мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмжийн нэгдсэн бүртгэлийн систем”-ийг ашиглана.

2.5. Ажлын хэсгийн хурал дарга оролцсон 5 түүнээс дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдох ба шийдвэр нь хурлын тэмдэглэлд үндэслэсэн дүгнэлт, зөвлөмж байна.

2.6. Ажлын хэсгийн нарийн бичгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс томилох бөгөөд нарийн бичиг нь хурлын тэмдэглэлийг хөтөлж, хуралд саналын эрхгүй оролцоно.

2.7. Ажлын хэсгийн хуралд тухайлсан асуудал бүрээр санал хурааж,

зарчмын зөрүүтэй саналыг энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хурлын тэмдэглэлийг хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөрт тооцно. /Хуралд оролцоогүй гишүүн холбогдох материал болон хурлын тэмдэглэлтэй танилцсанаас хойш ажлын нэг хоногт багтаан саналаа өгнө./

2.8. Ажлын хэсгийн хуралд холбогдох эрүүл мэндийн болон бусад салбарын мэргэжлийн зөвлөл, мэргэжлийн холбоодын төлөөллийг саналын эрхгүйгээр оролцуулж болно.

2.9. Ажлын хэсгийн гишүүн нь программ хангамжаа үнэлүүлэх хүсэлт ирүүлсэн байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглох бөгөөд сонирхлын зөрчилгүй болох тухайгаа үнэлгээний үйл ажиллагаа эхлэхээс өмнө бичгээр мэдэгдсэн байна.

2.10. Программ хангамжийн үнэлгээтэй холбоотой санал, гомдлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд гаргана.

Гурав. Программ хангамжид үнэлгээ хийх, мэдээлэх

3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж хөгжүүлэгч нь хөгжүүлсэн программ хангамжаа үнэлүүлэх тухай хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.1.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

3.1.2. Байгууллагын танилцуулга, туршлага, хүний нөөцийн мэдээлэл;

3.1.3. Программ хангамжийн модулийн жагсаалт, ашиглаж буй технологи, ажиллах үйлдлийн систем, тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга;

3.1.4. Мэдээллийн сүлжээ болон программ хангамжийн бүтэц схем (topology schema);

3.1.5. Программ хангамжид ашиглагдаж буй гуравдагч талын сервис ашиглах бол тэдгээрийн жагсаалт;

3.1.6. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас тухайн программ хангамжид хийсэн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;

3.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн бүрдүүлбэрийн шаардлага хангасан эсэхийг ажлын 3 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан бол ажлын хэсэгт болон хүсэлт гаргагч этгээдэд, шаардлага хангаагүй бол хүсэлт гаргагч этгээдэд бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

3.3. Ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан энэ тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан шаардлагын дагуу программ хангамжид үнэлгээ хийж, дараах ангиллаар дүгнэлт гаргана.

3.3.1. Өрхийн эмнэлэг ашиглах боломжтой;

3.3.2. Сум, тосгоны эмнэлэг ашиглах боломжтой;

3.3.3. Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, амаржих газар, тусгай эмнэлэг, клиник эмнэлэг ашиглах боломжтой;

3.3.4. Тусгай мэргэжлийн төв ашиглах боломжтой;

3.3.5. Сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сэргээн засах төв ашиглах боломжтой;

3.3.5. Түргэн тусламжийн төв ашиглах боломжтой;

3.3.6. Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах байгууллага ашиглах боломжтой;

3.3.7. Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (лаборатори) ашиглах боломжтой.

3.4. Ажлын хэсэг “шаардлага хангаагүй” гэж дүгнэгдсэн программ хангамж хөгжүүлэгчид холбогдох зөвлөмжийг хүргүүлнэ.

3.5. Программ хангамж хөгжүүлэгч “Шаардлага хангасан” гэж дүгнэгдсэн программ хангамжийн талаарх мэдээллийг тухайн дүгнэлт гарч, баталгаажсанаас хойш ажлын гурав хоногт багтаан Үндэсний программ хангамжийн их дэлгүүр “Mindgolia.mn” дэмжих системд нийтэлж, олон нийтэд мэдээлнэ.

3.6. Энэ журмын 3.4 дэх хэсэгт заасан программ хангамж нь “Mindgolia.mn” дэмжих системд байршсан бусад программ хангамжаас ялгагдах тэмдэглэгээтэй байх ба тус тэмдэглэгээг цахим хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.

3.7. Ажлын хэсгээс гаргасан дүгнэлт 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

---oOo---

Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2024 оны ... сарын.....өдрийн ...дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ашиглагдах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж нь дараах ерөнхий шаардлагын хангасан байна.

Д/д	Нэг. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	Зайлшгүй шаардлагатай	Зөвлөмжийн шинжтэй
1.1.	Эрүүл мэндийн сайдын баталсан анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтад нийцсэн байх	+	
1.2.	FHIR/HL7 стандартын дагуу мэдээлэл солилцохоор хөгжүүлсэн байх	+	
1.3.	Цахим хөгжил, харилцаа холбооны болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан эрүүл мэндийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, тайлбарыг ашигласан байх	+	
1.4.	Программ хангамж, өгөгдлийн сан нь оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй байх		+
1.5.	Программ хангамж нь тусламж, үйлчилгээний төрлөөр өртөг, зардлыг тооцоолох боломжтой байх /үйлчлүүлэгч эмнэлгээс гарах зардлыг тусгайлан тооцоолох гм/	+	
1.6.	Өвчний түүх, үйлчилгээний бүртгэлийн дугаарыг давхардуулахгүйгээр автоматаар үүсгэх ба тогтоосон хугацаа (жишээ нь: 1 сарын 1-нээс гм)-аас эхлэн мэдээллийг боловсруулдаг байх	+	
1.7.	Мэдээллийн эзнийг Монгол Улсын иргэний бүртгэлийн дугаараар таньж, тодорхойлох боломжтой байх	+	
1.8.	Мэдээллийн эзнийг оршин суух үнэмлэхийн дугаар (гадаадын иргэн, харьяалалгүй хүн)-аар таньж, тодорхойлох боломжтой байх	+	
1.9.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс бусад зорилгоор үйлчлүүлэгчийн мэдээлэлд хандахдаа мэдээллийн эзнээс, тухайн үйлчлүүлэгч мэдээлэл өгөх чадамжгүй тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс “Зөвшөөрөл” авах боломжийг бүрдүүлсэн байх	+	
1.10.	Үйлчлүүлэгчийн мэдээлэлд хандсан үед “Мэдэгдэл хүргэх” боломжтой байх	+	
1.11.	Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем (ХУР) болон эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны системтэй холбогдох боломжтой байх	+	
1.12.	Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбогдох боломжтой байх	+	

1.13.	Цахим гарын үсгийг дэмждэг байх	+	
1.14.	Программ хангамж хооронд болон аппликэйшн түвшинд нийтийн сүлжээ(public internet)-ээр мэдээлэл солилцохдоо мэдээллийг шифрлэсэн байх	+	
1.15.	Мэдээллийн утгын давхардлыг гаргаж, ижил утгыг , Мэдээллийн шивэлт давхардалгүй, боловсруулалтыг автоматаар хийдэг байх		
1.16.	Тайлан, мэдээллийг XLS, TXT гм олон төрлийн файлын форматаар татан авах, гаргах боломжтой байх	+	
1.17.	Тайлан, мэдээллийг хэвлэх боломжтой байх	+	
1.18.	Хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байх	+	
1.19.	Олон төрлийн үйлдлийн систем дэмждэг байх (WINDOWS, UNIX гэх мэт)		+
1.20.	Хандалтын тооноос хамаарч ачаалал даах чадвартай байх (Stress test result)	+	
1.21.	Мэдээллийг хугацааны интервал (өгөгдсөн хугацааны хооронд)-аар хайдаг байх	+	
1.22.	Программ хангамжийн ажиллагааны сануулга, анхааруулга өгдөг байх	+	
1.23.	Мэдээлэл солилцохдоо REST, SOAP протокол ашигладаг байх	+	
1.24.	Мэдээллийг дамжуулах, хүлээн авахдаа SSL холболттой байх	+	
1.25.	Эрх бүхий байгууллагаас тогтоосон цагийн улсын эталоныг ашигласан байх	+	
1.26.	Аудит бүртгэл (audit log)-ийг үүсгэх, хянах боломжтой модулийг хөгжүүлсэн байх	+	
1.27.	Шаардлагатай мэдээллийг нууцлах тохиргоо (mask)-той байх	+	
1.28.	Мэдээллийг нөөцөлдөг (backup) байх	+	
1.29.	Программ хангамжийн бүтцийн тохиргоог удирдах боломжтой байх (мэдээллийн төрөл, бүлэг, байгууллага, байгууллагын төрөл, салбарын бүлэг, тайлангийн тохиргоо гэх мэт)	+	
1.30.	Мэдээллийн сангийн мэдээллийг хугацаагаар түүхчилж хадгалдаг байх	+	
1.31.	Мэдээллийг баазын UNICODE ашигласан байх	+	
1.32.	Мэдээллийн сангаас гарах мэдээлэлд эх сурвалжийг тогтоох тэмдэглэгээтэй байх (ямар байгууллагын мэдээллийн сангаас мэдээлэл татагдсан талаарх тэмдэглэгээ, хугацааны хамт)	+	
1.33.	Программ хангамжийн тасалдал саатлыг бүртгэж, мэдээлдэг байх	+	
1.34.	Хэрэглэгчийн хандах эрхийн удирдлагатай байх (хэрэглэгч тус бүрээр үйлдлийг тохируулдаг байх)	+	
1.35.	Хэрэглэгчийн нэвтрэх нэр “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн систем” дэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн кодтой уялдсан байх	+	
1.36.	Хэрэглэгчийн үйлдлийн тохиргоо нь “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн систем” дэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй уялдсан байх	+	
1.37.	Программ хангамжид хандсан, нэвтэрсэн, боловсруулсан, баяжуулсан үйлдэл, цаг хугацааг бүртгэх логтой байх	+	
1.38.	Хэрэглэгчийн нэвтрэх оролдлогын тоог хязгаарладаг байх	+	

1.39.	Хэрэглэгчийн үйлдэл тодорхой хугацаагаар идэвхгүй болоход холболт автоматаар салдаг байх (session)	+	
1.40.	Хэрэглэгч нууц үгээ мартсан тохиолдолд админы дэмжлэггүйгээр сэргээх боломжтой байх	+	
1.41.	Нууц үгийг шифрлэн /encrypt/ хадгалдаг байх	+	
1.42.	Программ хангамжийн хөгжүүлэлтийн орчин буюу туршилтын орчин бүрдүүлсэн байх	+	
1.43.	Программ хангамжийн интерфэйс монгол хэл дээр байх		+
1.44.	Программ хангамжийн тохиргооны болон суурилуулалтын гарын авлагатай байх	+	
1.45.	Программ хангамжийн хэрэглэгчийн гарын авлагатай байх	+	
1.46.	Сервисүүдийн оролт, гаралтыг тодорхойлсон бичиг баримттай байх	+	
1.47.	Үйлчилгээний нөхцөл, шаардлагатай байх		+

Хоёр. ТУСГАЙ ШААРДЛАГА

Д/д	МОДУЛИЙН НЭР	ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ (заавал шаардлагатай модулийг "+" тэмдгээр тэмдэглэв)								
		Өрхийн эмнэлэг	Сум, тосгоны эмнэлэг	Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, амаржих газар, тусгай эмнэлэг, клиник эмнэлэг	Сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сэргээн засах төв	Тусгай мэргэжлийн төв	Түргэн тусламжийн төв	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах байгууллага	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага (лаборатори)	Нийгмийн эрүүл мэндийн төв
2.1	Цахим бүртгэл	+	+	+	+	+	+	+	+	+
2.2	Удирдлагын хяналт, мэдээлэл	+	+	+	+	+	+	+	+	+
2.3	Амбулатори	+	+	+	+	+				+
2.4	Хэвтэн эмчлүүлэгчийн бүртгэл (стационари)		+	+	+					
2.5	Яаралтай тусламж		+	+	+		+			
2.6	Сувилахуй	+	+	+	+	+	+			
2.7	Лаборатори	+	+	+	+	+	+		+	+
2.8	Дүрс оношилгоо	+	+	+	+	+	+		+	+

